


Зэврэлт - Далд аюул

August 2024



1-р зураг.



2-р зураг.

1. CSB тайлан No. 2012-03-I-CA, 2015 оны 1 сар

2. CCPS фото

Юу болсон бэ?

1-р зурагт хуучин шугам сүлжээ зэвэрсэн байгаа нь харагдаж байна. Гэвч уг шугам сүлжээг дараагийн үзлэг хийх хүртэл үргэлжлүүлэн ашиглахаар шийдсэн. Улмаар шугам задарч өндөр температуртай, шатамхай шингэн асгаран ойр орчимдоо ууршин тархсан. Гал авалцаж, томоохон түймэр дэгдсэн. Хүн нас бараагүй.

2-р зурагт Шингэрүүлсэн байгалийн хийн танкийг даралттай туршилтад оруулж байна. Туршилтыг ус (хувийн жин 1.0) ашиглан хийсэн бөгөөд байгалийн хий (хувийн жин 0.45)-ээс 2 дахин нягт. Танкны хөлийг гал тэсвэрлэх бүрхүүлээр хамгаалсан ба бүрхүүлийн доогуур зэврэлт үүссэнийг мэдээгүй. Усны ачааллаас болж танкны хөл хугарсан. 1 хүн гэмтэж, 1 хүн нас барсан.

Та мэдэх үү?

- Технологийн тоноглол, суурь байгууламжийн дотор, гадна, хаана ч зэврэлт үүсэх боломжтой.
- Зэврэлт гэдэг нь металл гэх мэтийн материал орчны хүчин зүйлтэй урвалд орохыг хэлнэ. Хамгийн түгээмэл нь төмөр, ган зэвэрч, төмрийн исэл буюу зэв үүсдэг.
- Зэврэлт үүсэх олон механизм бий. Зурагт зөвхөн 2 төрлийг үзүүлсэн.
- Зэврэлт нь ихэнхдээ удаан явцтай, тоног төхөөрөмж эвдрэх хүртэл олон жил болдог. Гэвч зарим тохиолдолд маш эрчимтэй зэврэх нь ч бий.
- Зэврэлтийн явц жилд хэдэн милли инч (1 милли инч = 25.4 микрон), микрометр (микрон)-ээр хэмжигдэнэ. Зэврэлтийн мэдээллийг ашиглахдаа зэврэлтийн хурдыг ямар нэгжээр илэрхийлснийг анхаарах хэрэгтэй.
- Хүчиллэг материал бетоныг зэврүүлдэг. Ингэснээр танк, шугам хоолойн гадуурх хоёрдогч агууламж, ачих/буулгах ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлнө.
- Зөвхөн металл л зэвэрдэг юм биш. Сальник, О цагариг, металл бус материалууд зэвэрч мэднэ.

Та юу хийх ёстой вэ?

- Үзлэг шалгалт хийхдээ тусгаарлагчийн өнгө өөрчлөгдсөн, тоног төхөөрөмж, шугам хоолой, байгууламж дээр толбо тогтсон, бетон эмтэрч гэмтсэн зэрэг зэврэлтийн шинж тэмдгийг ажиглаж бай.
- Тусгаарлагч гэмтсэн, тусгаарлагч, гал тэсвэрлэгч давхарга руу ус нэвчиж орсон эсэхийг ажигла.
- Тусгаарлалттай шугам хоолойноос дусаал дусаж байвал тусгаарлагч гэмтсэн, эсвэл шугам хоолой цоорсон байж мэднэ. Дусаал дусаж байгаа тохиолдол болгоныг анхааралтай шалгаж, ахлах ажилтандаа мэдэгд. Зохих ХХХ ашиглалгүйгээр цоорлыг олох гэж бүү оролд.
- Шугам хоолой, тоног төхөөрөмжийг нээж үзэхдээ сальник, О цагариг зэргийг шалга. Өнгө нь өөрчлөгдөх, хагарах зэргээр зэврэлтэд өртсөн шинж тэмдэг илэрвэл ахлах ажилтандаа мэдэгд. Сальник, О цагариг зэрэг нь тухайн хэрэглээнд тохироогүй байж мэднэ.

Зэврэлт – Үйлдвэрийн дотор, гадна, эргэн тойронд тохиолдох боломжтой. .